

**ГАН ХИЙЦ ХК-НИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Улаанбаатар хот

2022.04.07

Ган хийц ХК-ний хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 10:00 цагт компанийн ТУЗ-ийн даргын өрөөнд хийв.

Хуралд: Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Өндөрхаан инвест ҮЦК-нд хувьцаатай Н.Болдбаатар, н.Эрдэнэ, Б.Чинбат, Мэргэнсанаа ҮЦК-д хувьцаатай Н.Төгөс нар оролцлоо.

Хурал тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 72,5 хувь буюу 175987 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн гэж үзэн хурлыг эхлэв.

Хурлыг нээж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга М.Даваасүрэн үг хэлэв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэргүүлэгчдийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгож батлуулах саналтай байна. Хувьцаа эзэмшигчдийн саналыг хурааж 100 хувийн саналаар Хурлын даргаар М.Даваасүрэн, гишүүдэд Т.Анхтуяа, Н.Төгөс нарын бүрэлдэхүүнтэйгээр батлав.

М.Даваасүрэн: Хурлыг эхэлхээс өмнө тооллогын комиссыг мөн байгуулж батлуулдаг байгаа. Тооллогын комиссыг дараах хүмүүсийг сонгох саналтай байна.

Тооллогын комиссын бүрэлдэхүүнд: Хүний нөөцийн менежер О.Мөнгөнтуул, Хангамжийн менежер Б.Мөнхголомт, Зургийн инженер Н.Номин нарыг оруулах саналтай байна.

ХЭ: /100 хувийн саналаар дэмжив/

Тооллогын комиссын гишүүд хуралдаж комиссын даргаа сонгож тогтоолоо танилцуулав:

М.Даваасүрэн: Тооллогын комиссын даргаар О.Мөнгөнтуул, гишүүдэд: Б.Мөнхголомт, Н.Номин нарыг оруулахаар шийдвэрлэсэн байна. Дээрх тогтоолыг батлах уу?

ХЭ: /100 хувийн саналаар дэмжив/

М.Даваасүрэн: Тооллогын комисс хэлэлцсэн 5 асуудал дээр саналын хуудас бэлдэж санал хураалт явуулна.

М.Даваасүрэн: Хурлын хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг тус тус танилцуулж батлуулав. Хурлыг 10:30 минутанд эхэлж, 12:00 минутанд дуусгахыг санал оруулж батлууллаа.

Хэлэлцэх асуудлыг танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх санал оруулж байна. /Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар зөвшөөрөв./

М.Даваасүрэн хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах
2. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв, Компанийн 2023 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хэлэлцсэн нь:

М.Даваасүрэн: Хэлэлцэх асуудлыг бүгдийг нь танилцуулсаны дараа санал асуулгадаа орох уу?

ХЭ-100 хувь дэмжив.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийн талаарх мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар Ган хийц ХК-ний 2022 оны үйл ажиллагааны тайлан, Санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсэн. 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр цэвэр ашиг 2,816,696,000 төгрөг байхаар тооцсон боловч 624,204,000 төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Өмнөх онуудад борлуулалтаар хүлээн зөвшөөрсөн ч өртгийг хүлээн зөвшөөрөөгүй байсан 1,124,253,000 төгрөгийг өртөгт шингээснээр 22 хувийн ААК-тай ажиллах байсан нь 8 хувь болон буурсан үзүүлэлттэй байна.

М.Даваасүрэн: Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар Ган хийц ХК-ний 2022 оны үйл ажиллагааны цэвэр ашгийг 624,204,000 (зургаан зуун хорин дөрвөн сая хоёр зуун дөрвөн мянга)-н төгрөгөөр батлаж үйл ажиллагааны 90 хувь болох 561,783,600 (таван зуун жаран нэгэн сая долоон зуун наян гурван мянга зургаан зуу)-н төгрөгийг 2023 онд компанийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах ажилд зарцуулж, нийт ашгийн 10 хувь болох 62,400,000 (жаран хоёр сая дөрвөн зуун мянга)-н төгрөгийн 24,246,400 (хорин дөрвөн сая хоёр зуун дөчин зургаан мянга дөрвөн зуу)-н төгрөгийг ногдол ашгийн нэгж хувьцаанд 100 төгрөгөөр тогтоож, холбогдох Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгох, үлдэгдэл 38,177,600 (гучин найман сая нэг зуун далан долоон мянга зургаан зуу)-н төгрөгийг удирдлага менежментийн багт урамшуулал болгон олгох шийдвэрийг гаргасан. Ногдол ашгийг 30 брокер диллерийн компаниар дамжуулан 140 хувьцаа эзэмшигчдэд тараахаар шийдвэрлэсэн.

М.Даваасүрэн: ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв, Компанийн 2023 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах асуудлыг танилцуулав.

2023 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 243,591,500 төгрөгөөр тогтоох, Компанийн үйл ажиллагааны 2023 оны төсвийг 798,055,900 төгрөгөөр тогтоох төсөвлөсөн байна.

М.Даваасүрэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудит, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын гэсэн 3 хороотой бөгөөд 9 гишүүний орон тоотой ба одоогоор 1 гишүүн дутуу байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хуралдаа тогтмол оролцож, санал хүсэлтээ илэрхийлж ажилласан. 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 27 тогтоол шийдвэр гаргасан бөгөөд үүнээс 3 тогтоол нь ТУЗ-ийн гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна. **Үүнд:** Ногдол ашиг тараах шийдвэр II/15, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай II/15, Тайлан баталгаажуулах тухай II/15 гаргасан байна.

М.Даваасүрэн: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж сонгох асуудлыг танилцуулав.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээс Ц.Жанлав, Д.Энхбаатар нар өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн тул дээрх хүмүүсийг чөлөөлж, сул орон тоон дээр Д.Оюунзул, О.Ууганцэцэг, Б.Ганбат нарыг ТУЗ-ийн гишүүнээр оруулахаар нэр дэвшүүлж байна. Мөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Анхтуяаг жинхлэн томилох саналтай байна. Та бүхэн дээрх хүмүүсийн анкеттай танилцаж дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж дууслаа. Ингээд та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Өндөрхаан инвест ҮЦК Н.Болдбаатар: Хэлэлцсэн асуудал дээр нэмэх санал байхгүй. Дэмжиж байна.

н.Эрдэнэ: Санал хүсэлт байхгүй тул дэмжиж байна.

Б.Чинбат: Хэлэлцэж байгаа асуудлууд бүгд тодорхой танилцуулагдсан тул татгалзаж, асуул тодруулах зүйл байхгүй. 100 хувь дэмжиж байна.

Н.Төгөс: Асууж тодруулах зүйл байхгүй. Дэмжиж байна.

М.Даваасүрэн: Өөр асууж тодруулах зүйл байна уу? Байхгүй бол Тооллогын комисс байгуулж ажилд нь оруулъя.

М.Даваасүрэн: Тооллогын комисс хэлэлцсэн 5 асуудал дээр саналын хуудас бэлдэж санал хураалт явуулна.

Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсаа тарааж өгнө үү. /Хувьцаа эзэмшигчид саналын хуудастай танилцаж саналын хуудсыг бөглөв/

Тооллогын комиссын дарга Т.Анхтуяа саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол, тогтоолыг уншиж танилцуулав. /хурлын протокол, тогтоолыг хавсаргав/

М.Даваасүрэн: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгогдсон О.Ууганцэцэг, Д.Оюунзул, Б.Ганбат нартаа баяр хүргэж ажлын амжилт хүсье.

Шийдвэрлэсэн нь:

- 2023 оны ТУЗ-ийн зардлын төсвийг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар 243,591,500 төгрөгөөр тогтоох, Компанийн үйл ажиллагааны 2023 оны төсвийг 798,055,900 төгрөгөөр тогтоох,
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэх,
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээс Ц.Жанлав, Д.Энхбаатар нарыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, Д.Оюунзул, О.Ууганцэцэг, Б.Ганбат нарыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн томилох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Анхтуяаг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн жинхлэн томилов.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргаж буй тогтоолыг уншиж танилцуулсанаар хурал өндөрлөв. /тогтоолыг хавсаргав/
Хувьцаа эзэмшигчдийн хурал 12:03 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөгжсөн.

Нарийн бичгийн дарга:

Т.Анхтуяа

Танилцсан:

Хурлын дарга:

М.Даваасүрэн